




МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ  
АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО  
ӨӨРИЙГӨӨ ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГА



**MONGOLIAN  
OTC MARKET**  
БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛ



МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА  
ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО ӨЗБ

# 2023 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо”  
Өөрийгөө зохицуулах байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайлан

+ (976) 7012-3339






WWW.MASD.MN

INFO@MASD.MN



## АГУУЛГА

---

-  **МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО**
-  **ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ЭРХ АШИГ, ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**
-  **ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЭРХ АШИГ, ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР**
-  **СУРГАЛТ СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР**
-  **БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЙЛАН**





Монголын хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн байгууллагууд бид Монгол Улсын хөгжилд зах зээлийнхээ байр суурийг нэмэгдүүлэх нэг зорилгын доор эвлэлдэн нэгдээд 30 жилийн босгон дээр ирлээ.

Зах зээлд маань олон оновчтой бодлого гарч, зохицуулалтын орчин хурдацтай шинэчлэгдэж, мэргэжлийн оролцогчид болон Холбооны үйл ажиллагаа эрчимтэй тэлж, үр бүтээл ихтэй, завгүй он жилүүд өнгөрлөө.

Холбооны зүгээс засаглал, хяналт, дотоод үйл ажиллагаагаа улам чанаржуулж, институцийн байр суурийг бэхжүүлж, Холбооны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэ төрлийн мэргэжлийн байгууллагуудыг гишүүнээр элсүүлэх боломж бүрдүүлж чадсан бөгөөд энэ онд бид гишүүдийнхээ тоог 7-оор нэмээд байна. Холбооны дэргэд Комплаенсын зөвлөл, хуульчдын клуб, нягтлан бодогчдын клуб, Ахмадын зөвлөл албан ёсоор байгуулагдаж бодит үр дүнтэй ажлуудыг багагүй зохион байгууллаа. Мөн зохицуулагч байгууллагатай хамтран ажиллаж, Өөрийгөө зохицуулах байгууллагын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх чиглэлд тодорхой амжилт гаргаж чадлаа. Мөн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн зарим үйл ажиллагаа цахимжиж харилцагчид болон үнэт цаасны компаниудын үйл ажиллагааг хөнгөвчилсэн шинэчлэлүүд хийгдэхэд Холбоо болон гишүүн байгууллагуудын санаачилга чухал ач холбогдолтой байлаа.

Биржийн бус зах зээлийг тэлэх, чанаржуулах, хөрөнгө оруулагчийн тоог нэмэгдүүлэх, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хаалттай хувьцаат компанийн хувьцаа, хөтөлбөртэй бондын зохицуулалтыг бий болголоо. Үнэт цаас гаргагчдын хувьд Биржийн бус зах зээл хөрөнгө оруулалт татах хамгийн таатай зохицуулалтыг бий болгож үүний үр

дүнд 2023 онд нийт 63 компанийн 75 өрийн хэрэгслийг бүртгэсэн нь өмнөх оноос 74 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээрээс онцолж хэлэхэд үнэт цаас гаргагч аливаа зуучлалгүйгээр үнэт цаасаа бүртгүүлэх боломжтой болсон бөгөөд бүртгэлийн хорооны гишүүдийн тоог нэмэгдүүлж, шийдвэр гаргах үйл ажиллагааг улам уяан хатан, тодорхой болгосон юм.

Биржийн бус зах зээл дээр Олон Улсын хөрөнгийн зах зээлд шинээр нэвтэрч буй блокчэйн арилжааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж Зохицуулалт сэндрокс орчинд туршиж байна. Бид биржийн бус зах зээлд технологийн дэвшлийг нэвтрүүлэхээс гадна тогтвортой санхүүжилтийг нэвтрүүлэх зорилгоор Япон Улсын арилжаа эрхлэгчдийн холбоо (JSDA)-той байгуулсан санамж бичгээ шинэчлэн байгууллаа. Мөн хоёр Холбооны хамтын ажиллагаа улам бэхжиж, бид 2025 онд Азийн үнэт цаасны форумыг Монгол Улсад зохион байгуулах хүндтэй үүрэг хүлээгээд байна. Энэхүү форумыг Монголд Улсад зохион байгуулах нь дотоодын зах зээлийг олон улс, бүс нутагт таниулах, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих онцгой ач холбогдолтой юм.

Холбоо гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, зах зээлийн хөгжил, шинэчлэлт, амжилтыг бүс нутагт таниулах зорилгоор Япон Улсад бие даан, Хонг Конг, Шанхай хотуудад зохицуулагч байгууллага болон дэд бүтцийн байгууллагатай хамтран нэгдсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулсан билээ.

Холбоо хөрөнгийн зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгох сургалтын шинэ системийг нэвтрүүлсэн билээ. Энэ жил бидний хувьд мэргэжилтний ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажилласан бөгөөд Ёс зүйн хорооны үйл ажиллагаа шинэ түвшинд гарсан гэж дүгнэж байна.

Эцэст нь бид маш шаргуу ажилласан сүүлийн 5 жилийн амжилтаа тодотгох зорилгоор Холбооны хамгийн чухал ёслол болох ГрандБулл арга хэмжээнд 94 нэр дэвшигчдээс 15 номинацийн эздийг тодруулсан билээ. Энэ нь хөрөнгийн зах зээлийн өрсөлдөөн, хөгжил шинэ түвшинд гарсныг нотолж, бахархал төрүүлсэн нэр хүндтэй арга хэмжээ болсон. Холбооныхоо нийт гишүүн байгууллагууд, нийт зах зээлийн мэргэжилтнүүддээ өнөөдрийн амжилтаа улам ахиулах амжилт хүсээд Холбооны үйл ажиллагааг үргэлж дэмжиж хамтран ажиллаж байгаад гүн талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн:

Ц.Наран-Учрал / МҮЦАЭХ-ны Удирдах зөвлөлийн дарга/



Хөрөнгө оруулагчид болон гишүүн байгууллагуудын нийтлэг эрх ашгийг хамгаалж ёс зүйн стандартыг тогтоож шударга, ил тод, нээлттэй зах зээлийг бүрдүүлэн хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийг бий болгох зорилгын доор 2023 оны ажлын тайланг хүргэж байна.

Байгуулагдсан он:

ӨЗБ болсон:

Бусад улсын гишүүнчлэл:

1995

2015



2023 онд 3 мэргэжлийн, 4 хамтрагч гишүүн шинээр элсэж нийт 76 гишүүнтэй болов.

- “БКО капитал ҮЦК” ХХК;
- “Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН;
- “Мазаалай капитал партнерс ҮЦК” ХХК;
- “Балансэд грөүт менежмент ҮЦК” ХХК;
- “Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси” ХХК;
- “Фиделитас партнерс” ХХН;
- “Монголын хөрөнгийн бирж” ХК тус тус гишүүнээр элсүүлэв.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
2023 ТАЙЛАН



45

Үнэт цаасны компани

15

Хөрөнгө оруулалт менежментийн компани

04

Дэд бүтцийн байгууллага

03

Кастодиан банк

02

Банк

02

Банк бус санхүүгийн байгууллага

01

Үнэлгээний компани

01

Олон улсын байгууллага

02

ҮЦЗЗ оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх

01

Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага

63

МЭРГЭЖЛИЙН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА

13

ХАМТРАГЧ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА

76

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



Ц.НАРАН-УЧРАЛ

ГИШҮҮД:



М.ОТГОНБААТАР



К.АЛИЯ



Ц.ХУЯГ



Ш.ЭНХМЭНД



О.ЭРДЭНЭГЭРЭЛ



Ч.ХАНДАА



Г.УЯНГАХИШИГ

“ 2023 онд Удирдах зөвлөлийн гишүүд нийт 17 удаа хөрөнгийн зах зээлийн цаг үеийн асуудлаар ээлжит болон ээлжит бусаар хуралдаж нийт 41 тогтоол гаргасан. ”

ХАРААТ БУС ГИШҮҮД:



Ц.СОДХҮҮ



Н.УЛААНХҮҮ



А.БАТБОЛД





# Бүх гишүүдийн ИХ ХУРАЛ 2023 → XXIV

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны бүх гишүүдийн XXIV Их хурал 2022 оны 3-р сарын 24-ны өдөр Улаанбаатар зочид буудлын танхимд зохион байгууллаа. Холбооны дүрмийн 18.2-т Холбооны их хуралд уг хурал болох өдрийн байдлаар Холбооны гишүүдийн бүртгэлд бүртгэгдсэн мэргэжлийн гишүүн байгууллагын олонх ирснээр хүчин төгөлдөр болно гэж заасан бөгөөд саналын эрхтэй 61 мэргэжлийн гишүүдээс өөрийн биеэр 29 гишүүн, 9 итгэмжлэлтэй төлөөлөл оролцсоноор 62.2% ирцтэй хурал боллоо.

Их хурлын тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд Ц.Содхүү /МУЦАЭХ/, Ц.Дөлгөөн /Улаанбаатар ассет менежмент ХХК/, Д.Мөнхбат /Эм би ви си ххк/ нар, Их хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүнд Л.Гантуяа /Аргай бест ҮЦК ХХК/, М.Мөнхтуяа /Мандал ассет менежмент ҮЦК ХХК/, П.Сэлэнгэ /Апекс капитал ҮЦК ХХК/ нар сонгогдон ажиллалаа.

Их хурлаар Холбооны дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн хуралд оролцогчдын олонхын санал буюу 84.2%- р дэмжиж Санхүүгийн зохицуулах хороогоор батламжлуулж, Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр боллоо.



## Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо

# 2023



Удирдах зөвлөлийн даргаар Цэдэвийн Наран-Учрал томилогдлоо.

Холбооны Удирдах зөвлөлийн 2023 оны 4 дүгээр сарын ээлжит хурлаар Удирдах зөвлөлийн дарга Арьяасүрэн овогтой Батболдын сонгуульт албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтийг ёсоор болгож, Цэдэв овогтой Наран-Учралыг хуралд оролцогчдын 80 хувийн саналаар Удирдах зөвлөлийн даргаар нөхөн сонголоо.

Ц.Наран-Учрал нь ажлын гараагаа 2010 онд “Нортенсек ҮЦК” ХХК (“Ард Капитал Групп ҮЦК” ХХК)-д шинжээч, гадаад арилжааны дилерээр эхлүүлж, Нэйшнл сэкьюритис ҮЦК-ийн Гүйцэтгэх захирал болон Бумбат-Алтай ҮЦК-ийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирлаар ажиллаж ирсэн.

Энэ хугацаанд үнэт цаасны зуучлал, нээлттэй болон хаалттай хөрөнгө босголтын ажил удирдах, хөрөнгө санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгөх, олон улсын бирж дээр үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож, удирдлагаар хангаж ирсэн хөрөнгийн зах зээлийн мэргэжилтэн юм.

Ц.Наран-Учрал нь өдгөө “Ди Эйч Капитал ҮЦК” ХХК-н Гүйцэтгэх захирлаар ажилладаг. Мөн Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Түмэн шувуут” ХК болон “Хөвсгөл Алтандуулга” ХК-н төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.



# Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо

# 2023

Японы үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь Японы үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтран ажиллах санамж бичгийг 2023 оны 06 сарын 23-ны өдөр Япон улсын Токио хотод шинэчлэн байгууллаа. Тус санамж бичгээр тогтвортой санхүүжилт, дижитал бүтээгдэхүүнийг хоёр орны зах зээлд нэвтрүүлэх, зохицуулалтын орчныг бий болгох, түүнийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах юм. Өмнө нь 2016 онд хоёр байгууллага санамж бичгийн хүрээнд Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, зах зээлийн хууль тогтоомж, арилжааны туршлага, хөрөнгө оруулалтын шинэ хэрэгсэл үйлчилгээний ажлуудыг эхлүүлж байсан.

Энэхүү уулзалтын хүрээнд Японы хөрөнгө оруулагч, мэргэжлийн оролцогчдод Монгол төслүүдийг болон өөрийн үйл ажиллагаа болон одоо ажиллаж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар товчхон танилцуулгууд хийгдсэн. Танилцуулгын үеэр манай талаас Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, “Ти ди би секюритис ҮЦК”ХХК, “Инвескор капитал ҮЦК”ХХК, “Голомт капитал ҮЦК” ХХК, Би Ди Сек ҮЦК”ХХК, “Сод ассет менежмент ҮЦК” ХХК “Алтан хоромсог ҮЦК”ХХК, Япон талаас Daiwa institute of Research Ltd, Nomura Institute of Capital Markets Research, Japan External Trade Organization(JETRO), Trans Bank Tokyo Representative Office, Japan Investor Protection Fund, Japan Securities Research Institute, Mitsubishi Corporation, the investment trusts Association,Japan, mitsubishi UFJ Morgan Stanley Securities Co., Ltd төлөөллүүд оролцлоо.

Айлчлал нь хоёр орны хооронд хийгдэж буй хөрөнгө оруулалт, түүнтэй холбоотой санхүүгийн бусад үйлчилгээнүүдийг мэргэжлийн байгууллагуудаар дамжуулах, урт хугацаанд хоёр орны хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэхэд Холбоод, мэргэжлийн оролцогчдын зүгээс мэргэжлийн түвшинд тогтвортой хамтран ажиллах, урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх алхам боллоо.



## Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо

# 2023

**Азийн үнэт цаасны форумын бүх гишүүдийн XXVIII Их хурал БНЭУ-ын Мумбай хот.**



2023 оны 10-р сарын 29-с 11-р сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулагдаж 17 улсын 50 гаруй зочид төлөөлөгчид оролцлоо. Чуулга уулзалтад Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоог төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга Ц.Наран-Учрал, Гишүүд, хамтын ажиллагаа хариуцсан менежер Э.Мөнх-Өргөө нар оролцож Монгол Улсын зах зээлийн тойм, хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал хөрөнгө оруулалтын хэтийн төлөв болон эрх зүйн орчны талаар дэлгэрэнгүй илтгэл тавьж сурталчлан танилцууллаа.

JSDA-н Удирдах Зөвлөлийн дарга, Азийн үнэт цаасны форумын ерөнхий нарийн бичгийн дарга ноён Тошио Морита нь зочид төлөөлөгчдийг хүлээн авч өөрийн улс орноо төлөөлж идэвхтэй оролцож байгааг сайшаан талархал илэрхийллээ. Холбооны Удирдах зөвлөлийн дарга Ц.Наран-Учрал ноён Тошио Моритатай биечлэн уулзаж улс орноо сурталчлан танилцуулах боломж олгосонд талархал илэрхийллээ. Өнгөрсөн удаа Холбооноос Япон улсад зохион байгуулсан "Road show" болон тус чуулга уулзалтад оролцож байгаа явдал нь хоёр орны хөрөнгийн зах зээлийн хамтын ажиллагааны хөгжилд бас нэгэн алхам болсон төдийгүй JSDA болон MASD хоёр холбооны хооронд байгуулсан хамтран ажиллах баримт бичигт чухал ач холбогдол өгч цаашдын хамтын ажиллагаагаа бататган өргөжүүлэх нэгэн том жишээ боллоо.

Чуулга уулзалтад Холбооны Удирдах зөвлөлийн дарга Ц.Наран-Учрал "Хөрөнгийн зах зээл дэх технологийн дэвшил болон дижитал шилжилт сэдвийн хүрээнд панелаар оролцож олон улсын хөрөнгийн зах зээлийн оролцогч мөн зохицуулагч байгууллагуудын технологийн шилжилтийн талаар дэлгэрэнгүй ярилцаж ирээдүйн чиг хандлагыг хэлэлцлээ.



## Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо

# 2023



Хамтын ажиллагааны санамж бичгүүд:

- **“Мост Финтек” ХХК, “Грэйп сити Монгол” ХХК & МҮЦАЭХ**
  - МҮЦАЭХ-ны гишүүн ҮЦК-иуд нь Монголын үнэт цаасны арилжааны зах зээлд дижитал шилжилтэд тэргүүлж буй ГрэйпСити Монгол ХХК-ийн хөгжүүлсэн КАСПО суурь систем, мобайл аппликэйшн, харилцагчийн веб зэрэг технологийн өндөр түвшинд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөнгөлттэй үнээр гишүүн байгууллагуудад нэвтрүүлэх боломжийг бүрдүүлж буй юм.
- **“Концепт интернэшнл ХХК” & МҮЦАЭХ**
  - Стратегийн түншлэлийн санамж бичгийн хүрээнд талууд Монголын хөрөнгө оруулалтын зах зээлийг тэлэх, биржийн бус зах зээлийн Эдийн засгийн өсөлтөд үзүүлэх потенциалыг нэмэгдүүлэх ажлуудыг хамтран хэрэгжүүлэх зорилготой.
- **“Монголын тогтвортой санхүүгийн холбоо” & МҮЦАЭХ**
  - Монголын үнэт цаасны зах зээлд хамтын ажиллагааг оновчтой, үр өгөөжтэй, тогтвортой хөгжлийн зарчимтай уялдуулан, хүртээмжтэйгээр зохион байгуулж, тогтвортой санхүүгийн зарчмуудыг таниулан ойлгуулах зорилготой.
- **“Өмгөөллийн Фиделитас Партнерс” ХХК & МҮЦАЭХ**
  - Холбооны өөрийгөө зохицуулагч байгууллагын статусыг бэхжүүлэх, үйл ажиллагааг үр нөлөөтэй, оновчтой байхад хууль зүйн мэргэжлийн үйлчилгээгээр Хуулийн фирм дэмжлэг үзүүлж, урт хугацааны харилцан ашигтай хамтын ажиллагааны суурийг бэхжүүлэхэд чиглэнэ.



# Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо

# 2023



## Зохицуулалтын орчинд оруулсан өөрчлөлтүүд:

- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль
  - "Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөр тооцооны бэлэн байдлыг хангаж, тус хуульд заасан журмын төслүүдийг хамтран боловсруулах" чиг үүрэг бүхий ажлын хэсэгт Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Буянхишиг орж ажилласан.
- ҮЦТХТ-ийн Биржийн бус зах зээлийн харилцааг гэрээгээр зохицуулж байсныг журмаар зохицуулахаар тохиролцож журмын төсөлд санал өгсөн.
- Биржийн бус зах зээлийн ерөнхий журам 2023 оны 7 сарын 5-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны дарга батламжилсан.
- Биржийн бус зах зээлийн бүртгэлийн журам 2023 оны 1 сарын 11-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаалаар батламжилсан.



# Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо

# 2023



## Олон улсын онлайн хурлууд:

- ICMA Annual General Meeting and Conference
- ICMA FinTech and Digitalisation Forum
- Commercial paper as a funding and investment tool
- Accelerating Transition with Sustainable Bonds: 7th Annual ICMA & JSDA Sustainable Bond Conference
- ASIFMA Capital Markets Conference
- ASIFMA Compliance Asia Conference
- ASIFMA Scaling up Sustainable Finance in Asia



## Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо

# 2023

Гишүүн байгууллагын шилдэг мэргэжилтнүүд төрийн дээд шагналууд гардаж авлаа.



Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны гишүүн байгууллагын мэргэжилтнүүд төр засагтаа үнэлүүлж УИХ Гишүүн, МҮЦАЭХ-ны Ерөнхийлөгч Д.Цогтбаатар, Санхүүгийн зохицуулах хорооны гишүүн Т.Цэрэнбадрал нараас төрийн дээд шагналуудаа гардаж авлаа.

- "Дархан Брокер ҮЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ж.Очирсүх хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдав.
- "Монсек ҮЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал М.Отгонбаатар Алтан гадас одонгоор шагнагдав.
- "Зэргэд ҮЦК" ХХК-ийн Брокер Б.Алтанцэцэг Алтан гадас одонгоор шагнагдав.
- "Тулгат Чандмань Баян ҮЦК" ХХК-ийн Брокер Л.Довчин Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдав.



## МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБООНЫ САХИЛГЫН ЗӨВЛӨЛӨӨС УРИАЛГА ГАРГАХ НЬ

Монголын хөрөнгийн зах зээл хөгжлийн шатандаа явж буй энэ цаг үед олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх чиглэлээр нийт мэргэжлийн оролцогчдыг нэгдмэл байр суурьтайгаар дараах чиглэлүүдэд санаачилга гарган ажиллахыг уриалж байна.

Тус санаачилгыг олон улсын хөрөнгийн зах зээлийн нийтлэг жишиг, хууль, журмын зохицуулалтуудыг үндэслэн гаргасан болно.

**Олон нийтэд таниулах дүр төрх:** “Хариуцлагатай, ёс зүйтэй Хөрөнгийн зах зээл”  
Хууль журмаар зохицуулаагүй, хөгжлийн шатанд явж байгаа хэм хэмжээ, нарийн зохицуулалт дутагдаж буй асуудлуудыг мэргэжилтнүүдийн дунд нээлттэй ярилцаж, санал бодлоо солилцох, хууль журам, ёс зүйг сайжруулахуйц санал санаачилга гаргахыг зах зээлд оролцогчид бүгд эрмэлзэх шаардлагатай.

**Мэргэжилтнүүд:** Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдын баримтлах ёс зүйн дагуу Зохицуулагч байгууллагуудаас хууль бус гэж тогтоогоогүй, зах зээлийн нэр хүндийг унагаж болзошгүй мэдээллийг олон нийтийн болон бусад хэрэгслээр мэдээлэхгүй байж, бусдын нэр хүндэд үндэслэлгүйгээр халдахгүй байх, зохих арга хэмжээ авах байгууллагуудад шүгэл үлээх. Олон нийтийн сүлжээ болон бусад мэргэжлийн үйл ажиллагаанд биеэ зөв авч явах.

**Шүгэл үлээх:** Шүгэл үлээх үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулах, эх сурвалжийг баталгаажуулалгүйгээр олон нийтэд зарлахыг хориглож, баталгаагүй зүйлсийг зарлаж, зах зээлийн нэр хүндийг хамгаалах ёс зүй болон бусад хууль журмыг зөрчсөн тохиолдолд буруутай этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх. Хэм хэмжээ, ёс зүй, дүрэм журам зөрчсөн тохиолдол гарах бүрд нэн түрүүнд Холбоонд болон зах зээлд оролцогчдынхоо түвшинд шүгэл үлээх.

**Андеррайтерууд:** IPO хийж байгаа бүтээгдэхүүний арилжаанд оролцохдоо баримтлах ёс зүйн стандарттай байж, түүнийгээ олон нийтэд танилцуулах, хөрөнгийн зах зээлд оролцогч иргэдтэй хөрөнгийн зах зээлийг төлөөлж харилцаж буй мэргэжилтэн гэдэг утгаараа зүй зохистой харилцах, зах зээлийн нэр хүндийг хамгаалах, өөрийн арилжаанаас түрүүлж харилцагчийн захиалгыг биелүүлэх ёс зүйн стандартаа баримтлах.

**Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо:** Хөрөнгийн зах зээлийн мэргэжилтнүүдийн ёс зүйн баримтлах дүрэм журмуудыг сурталчлан таниулах ажлуудыг тогтмол хийх

2023.05.17

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ЭРХ АШИГ, ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН  
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР



МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ  
АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО  
ӨӨРИЙГӨӨ ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГА



**INVEST KHOVD**  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ФОРУМ 2023

МОДЕРАТОР



**А.УНДРАЛ**

ТЭНГЭР ТЕЛЕВИЗИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



**Э.БОЛОРМАА**

ХОВД АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА



**С.МӨНГӨНЧИМЭГ**

САНГИЙН ДЭД САЙД



**Б.ЧУЛУУНБААТАР**

МОННИС ГРУППИЙН  
ЕРӨНХИЙЛӨГЧ



**Э.ЭРДЭНЭСҮРЭН**

МӨБИКОМ КОРПОРАЦИ  
ХӨХ ИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ,  
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ  
ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ



**И.ГАЛБУЯН**

"НОМИН ХОЛДИНГ" ХӨХ ИЙН  
БАРЛГА, ҮЛ ХӨДЛӨХ  
ХӨРӨНГИЙН БИЗНЕС  
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



**О.ОРХОН**

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН  
БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ



**Б.БУЯНХИШИГ**

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААС  
АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ХОЛБООНЫ  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

# Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр

# 2023

“Invest Khovd 2023” Хөрөнгө оруулалтын форум



Монгол Улсын баруун бүсийн тулгуур төв болох Ховд аймагт хөрөнгө оруулалт болон авьяас чадвартай чадварлаг боловсон хүчнийг татах, тус аймагт байгаа хөрөнгө оруулалтын таатай орчин, нөөц боломжийг танилцуулах, Ховд аймгийн болон Баруун бүсийн бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид, санхүүжүүлэгчдийн уулзах тавцанг бий болгож хөгжлийн гарц, шийдлүүдийг хөдөлгөөнд оруулах зорилгоор тус аймгийн Засаг даргын тамгын газраас “Invest Khovd 2023” хөрөнгө оруулалтын форумыг 2023 оны 1-р сарын 19-20 хооронд зохион байгууллаа. Энэхүү форумд баруун бүсийн хөрөнгийн зах зээл болон санхүүгийн салбарын боломжийг Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Буянхишиг панелистаар оролцож танилцууллаа.

Мөн Холбоо нь Ховд аймгийн засаг даргын тамгын газартай орон нутгийн бонд гаргах, Ховд аймгийн бизнес эрхлэгчид болон дэд бүтцийн байгууллагуудад хөрөнгө оруулалт татах, мэргэжлийн зөвлөгөө өгөх зорилгоор хамтран ажиллах санамж бичиг байгуулсан юм.



# Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр

# 2023

## Монголын хөрөнгийн зах зээлийн удирдан манлайлагч эмэгтэйчүүдийн уулзалт



Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооноос Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан гишүүн байгууллагуудын эмэгтэй захирлуудтай уулзалт зохион байгууллаа. Холбооны гишүүн байгууллагуудын хүрээнд 24 эмэгтэй захирал, нийт 200 гаруй эмэгтэй ажилчид байгаа нь гишүүн байгууллагын ажилчдын 60 гаруй хувийг эмэгтэй ажилчид эзэлж байна.

Уулзалтаар Хөрөнгийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн зах зээлд оруулах хувь нэмрийг дэмжих, тулгарч байгаа асуудлыг тодорхойлох, эмэгтэйчүүдэд чиглэсэн үйл ажиллагааг тогтмолжуулахыг зорилго болголоо. Уулзалтад Азийн сангийн суурин төлөөлөгч Марк Кэйниг болон эмэгтэйчүүдийн эдийн засгийн хөтөлбөрийн ажилтнууд оролцож "Азийн сан"-с хэрэгжүүлж байгаа эмэгтэйчүүдэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдээ танилцуулсан юм.

Гүйцэтгэх удирдлага болон шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлснээр эмэгтэйчүүдэд тулгардаг онцлог хэрэгцээ, сорилтуудыг ойлгож байгууллагын дотоод жендерийн тэгш байдал хангагдахыг уулзалтаар онцоллоо.



# Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр

# 2023

Хөрөнгийн зах зээлийн хөгжил, тулгамдсан асуудлууд, нөхцөл байдлыг тандах, салбар дахь судалгаа шинжилгээний бодит эрэлт хэрэгцээг тодорхойлох хэлэлцүүлэг



СЭЗИС-ийн Ахисан Түвшний Сургуулиас санаачлан Хөрөнгийн зах зээлийн хөгжил, тулгамдсан асуудлууд, нөхцөл байдлыг тандах, салбар дахь судалгаа шинжилгээний бодит эрэлт хэрэгцээг тодорхойлох, эрдэмтэн судлаачид, олон нийтийн анхаарлыг хандуулах, үйл ажиллагааг чиглүүлэх зорилготой салбарын гол оролцогчдын санал бодлыг сонсох уулзалт хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Бидисек үнэт цаасны компани, Мандал Ассет Менежмент компани зэрэг байгууллагын удирдлагууд уригдан оролцож судлаач багш нар сонирхсон асуултаа асууж хэлэлцүүлэг өрнүүллээ.

Хэлэлцүүлэгт оролцогчид Үнэт цаасны зах зээлийн хөгжил, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд, шалтгааны талаар санал бодлоо солилцож цаашдын хамтын ажиллагааны чиглэл сэдвийг тодорхойллоо.



# Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр

# 2023

Санхүүгийн зохицуулах хорооноос орон нутгуудад зохион байгуулж байгаа сургалт хэлэлцүүлэгт Холбооны гишүүн байгууллагууд иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэн ажиллалаа.



Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжихэд иргэдийн санхүүгийн мэдлэг боловсрол, оролцоо чухал үүрэгтэй. Ийм ч учраас Санхүүгийн зохицуулах хороо иргэд, олон нийтэд санхүүгийн боловсрол, мэдлэг түгээх сургалт хэлэлцүүлгийг 2013 оноос хойш жил бүр уламжлал болгон зохион байгуулсаар ирсэн. Харин ковидын цар тахал, хөл хорионы улмаас өнгөрсөн гурван жил зохион байгуулж чадаагүй. Иймээс энэ жилээс сургалт хэлэлцүүлгээ хойд бүсийн аймаг болох Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгаас эхлүүлэхээр Дархан-Уул аймагт нээлтээ хийсэн юм.

- Дархан хотод зохион байгуулсан сургалт хэлэлцүүлэгт иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэхээр Апекс капитал ҮЦК, БиДиСЕК ҮЦК, Гүүдсек ҮЦК, Дархан брокер ҮЦК, Мандал капитал маркетс ҮЦК, Өлзий энд ко капитал ҮЦК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нар ажиллалаа.
- Эрдэнэт хотод зохион байгуулсан сургалт хэлэлцүүлэгт иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэхээр Апекс капитал ҮЦК, БиДиСЕК ҮЦК, Гүүдсек ҮЦК, Мандал капитал маркетс ҮЦК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нар ажиллалаа.
- Сэлэнгэ аймагт зохион байгуулсан сургалт хэлэлцүүлэгт иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэхээр БиДиСЕК ҮЦК, Гүүдсек ҮЦК, Райнос Инвестмент ҮЦК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нар ажиллалаа.



# Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр 2023

**Санхүү, банкны эмэгтэйчүүдийн хоёрдугаар чуулган зохион байгуулагдаж Холбооны төлөөллүүд оролцлоо.**



Сангийн яам, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкны холбоодууд Санхүү банкны эмэгтэйчүүд ТББ-тай хамтран “Санхүү банкны эмэгтэйчүүдийн хоёрдугаар чуулган”-ыг төрийн ордонд зохион байгууллаа. Чуулганд төрийн байгууллагууд, банк, санхүү, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын манлайлагчид болон орон нутгийн төлөөллөөс нийт 650 гаруй төлөөлөгч оролцлоо. Энэхүү чуулганаар "Хариуцлагатай бизнес ба тогтвортой хөгжил", "Ажил амьдралын тэнцвэрийг хангах", "Оролцогч талуудын ашиг, сонирхлыг хүндэтгэх, хамгаалах" сэдвийн хүрээнд нээлттэй хэлэлцүүлэг өрнүүллээ. Чуулганд "Санхүүгийн салбарын жендерийн эрх зүйн зохицуулалт" сэдвээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн дарга Э.Ганхүү илтгэл тавьж, санхүү, банкны салбарт эмэгтэй ажилчид 68%-ийг эзэлж байгааг онцолсон юм.

Холбооны Удирдах зөвлөлийн дарга Ц.Наран-Учрал нь "Харилцагчийн эрхийг хүндэтгэн хамгаалахад, кодекс нэгдсэн стандартыг ашиглах" сэдвийн хүрээнд Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлэх эрх авсан мэргэжилтний баримтлах ёс зүйн дүрэм, мэргэжлийн үйл ажиллагааны стандартыг хэрэгжүүлдэг арга туршлагаас хуваалцсан юм.

Мөн Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Г.Уянгахишигийг Үнэт цаасны зах зээлийн төлөөлөл Санхүү, Банкны Тэргүүний эмэгтэй хэмээн онцолж, Санхүү, Банкны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагналаа.



# Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр

# 2023

## “Комплаенсын эрсдэлийг удирдахуй” нээлттэй хэлэлцүүлэг



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь Санхүүгийн зохицуулах хороо болон Санхүүгийн боловсролын HUB байгууллагуудтай хамтран үнэт цаасны салбарт мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ФАТФ-ын зөвлөмж, стандартыг үр дүнтэй биелүүлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, нэгдсэн ойлголтод хүрэх зорилгоор “Комплаенсын эрсдэлийг удирдахуй” нээлттэй хэлэлцүүлгийг 2023 оны 11 сарын 03-ны өдөр зохион байгууллаа.

Арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны төлөөллүүд болон үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн компаниуд, хөрөнгө оруулалт менежментийн компани, сангуудын 80 гаруй төлөөлөл оролцож “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлд суурилсан зохицуулалтын болон хяналт шалгалтын тогтолцоог боловсруулах, хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал”, “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний бодлого, стратеги, эрсдэлийн үнэлгээ”, “СЗХ-ны зохицуулалттай үнэт цаасны салбарын хууль эрх зүйн орчин, цаашид хийгдэх арга хэмжээ” гэсэн үндсэн илтгэлүүдтэй танилцлаа.

Оролцогчид үнэт цаасны зах зээл дэх комплаенсын эрсдэлийг хэрхэн тодорхойлох, хөрөнгө оруулалтын менежментийн компани болон хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа ба комплаенсын эрсдэлийн талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Мөн харилцагчийг таньж мэдэх ажиллагаа ба мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлд суурилсан зохицуулалтын болон хяналт шалгалтын тогтолцоог хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, үнэт цаасны салбарын хууль эрхзүйн орчин, цаашид хийх арга хэмжээний талаар мэдээлэл авч санал солилцлоо.



# Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр

# 2023

Салбарын дээд шагнал гардуулах ёслол “Grand Bull Awards-2023”



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч, үнэт цаас гаргагчдын шилдгийг шалгаруулах салбарын дээд шагнал гардуулах ёслол болох “Grand Bull Awards 2023” арга хэмжээг 12 дугаар сарын 01-ны өдөр амжилттай зохион байгууллаа. “Grand Bull Awards” шагнал гардуулах ёслолын арга хэмжээ нь анх 2013 онд тухайн үеийн Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллагуудын санаачилгаар зохион байгуулагдсан бөгөөд өдгөө 5 жил тутамд зохион байгуулагддаг төрийн болон хувийн хэвшлийн компаниуд, зах зээлийн мэргэжлийн оролцогчдыг нэг дор цуглуулж шилдгүүдээ шалгаруулдаг уламжлал болсон арга хэмжээ юм.

“Grand Bull Awards 2023” арга хэмжээний 15 номинацид 70 гаруй байгууллагын давхардсан тоогоор 94 нэр дэвшигчийн материал ирүүлсэн бөгөөд эдийн засгийн сэтгүүлчдийн төлөөллөөс бүрдсэн үнэлгээний баг 15 номинацийн эцсийн шатанд 60 нэр дэвшигчийг шалгаруулсан. Үнэлгээний зарчмын дагуу эцсийн шатны нэр дэвшигчдэд Холбооны гишүүн байгууллагууд болон зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийн гишүүд үнэлгээ өгч эцсийн шатны нэр дэвшигчдээс шилдгийн шилдэг гранд буллын эздийг тайзнаа тодруулсан юм.

ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЭРХ  
АШИГ, ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР



МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ  
АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО  
ӨӨРИЙГӨӨ ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГА



# Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

# 2023

## МУЦАЭХ-ны “Удирдах ажилтнуудын зөвлөгөөн”

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллагын "Удирдах ажилтнуудын зөвлөгөөн"-ийг 2023 оны 08-р сарын 25-ны өдөр "Highland Park Mongolia"-ын хурлын танхимд амжилттай зохион байгууллаа. Зөвлөгөөнд нийт 40 гаруй гишүүн байгууллагын удирдах ажилтан, төлөөлөл хамрагдлаа.

МУЦАЭХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Буянхишиг Холбооны 2023 оны хагас жилийн тайлан болон цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг танилцуулснаар эхэлсэн бөгөөд зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд болох "Монголын хөрөнгийн бирж", "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв", "Монголын үнэт цаасны клирингийн төв", "Улаанбаатар үнэт цаасны бирж", "Чингис хаан хөрөнгийн бирж" нарын удирдах ажилтан, төлөөллүүд оролцон байгууллагынхаа богино болон дунд хугацаанд хийх ажлуудаа танилцуулж, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар нийт гишүүдтэй хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Зах зээлд ойрын үед ёс зүйн зөрчлийн асуудлаар гомдол гарах нь ихсэж байгаа тул Холбооны Ёс зүйн хорооны гишүүд зөвлөгөөнд оролцож нийт гишүүн байгууллагуудад ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэхийг зөвлөж "Хөрөнгийн зах зээлд гарч буй нийтлэг асуудлууд, зохицуулалтын орчин" сэдвээр мэдээлэл хүргэлээ.

Холбооны дүрмийн шинэчилсэн найруулгын төслийн бүтэц, хэрэгцээ шаардлага, зарчмын өөрчлөлтүүдийг гишүүдэд танилцуулж, гишүүдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлж, санал бодлоо хэлэлцсэн юм.

## Recipients of ICMA's 2023 Scholarship Programme

ICMA is delighted to announce the successful recipients of its 2023 scholarship programme. The 23 individuals from Sub-Saharan Africa, 9 from Asia and 3 from Latin America were selected from an extensive number of applications received, based on their academic attainments and a personal statement on their suitability for their chosen course of study. The ICMA scholarship programme is part of ICMA's mission to raise standards and support inclusion in financial markets.



Rosalyn Ampah  
Ghana



Ransford Addison  
Ghana



Manojee Barla  
India



Sereyboth  
Chamroeun  
Cambodia



Do Minh Chau  
Vietnam



Robert Concepcion  
Peru



Warren Atunga  
Demsi  
Kenya



Tadewos Desta  
Ethiopia



Ariunzaya Enkh-  
Amgalan  
Mongolia



# Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

# 2023

## "ICMA Scholarship Programme 2023"



МҮЦАЭХ нь 2021 оны 7-р сараас ICMA /International capital market association/ Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоотой харилцан гишүүнчлэлтэй болсон бөгөөд, ICMA нь дэлхий даяар үйл ажиллагаа явуулдаг 620 гишүүнтэй олон улсын байгууллага бөгөөд бондын зах зээлээр мэргэшсэн юм.

"ICMA Scholarship Programme 2023"-д Монголоос Таван богд капитал ҮЦК-н Шинжээч Э.Ариунзаяа сонгогдлоо. ICMA тэтгэлэгт хөтөлбөр нь ICMA-ийн стандартыг дээшлүүлэх, санхүүгийн зах зээлд хамруулах үйл ажиллагааг дэмжих эрхэм зорилготой бөгөөд нэг жилийн хугацаанд цахимаар сургалтад хамрагдаж

- ICMA Diploma in Debt Capital Markets,
- ICMA Diploma Securities & Derivatives,
- ICMA Diploma in Financial Market Operations, хөтөлбөрүүдээс сонгон суралцах юм.



# Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

# 2023

Хөрөнгийн зах зээлд оролцогч байгууллагуудын “Спортын их наадам 2023”



Монголын хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын дунд уламжлал болгон зохион байгуулагдаж ирсэн “Спортын их наадам 2023” арга хэмжээг Санхүүгийн зохицуулах хороо нь 2023 оны 1-р сарын 17-ны өдрөөс 1-р сарын 22-ны өдрүүдэд зохион байгууллаа. Холбоо нь Монголын хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудад ажиллаж буй мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, спортоор хичээллэн эрүүл мэндээ сайжруулахад хувь нэмрээ оруулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, спортын талбарт шударгаар өрсөлдөх, спортын шилдгүүдийг алдаршуулах зорилго дор тэмцээний ерөнхий зохион байгуулагчаар хамтарч ажилласан.

Энэ удаагийн тэмцээний онцлог нь уламжлалт спортын таван төрөлт тэмцээн дээр Монголын уламжлалт наадгай “Шагайн харваа”-н спортын төрлийг нэмж оруулсан нь юм.

Холбооны баг нь гишүүн байгууллагуудын мэргэжилтнүүдээс бүрэлдүүлж орсон ба байр эзэлсэн мэдээллийг хүргэв.

- “Шатар”-ын төрөлд “Тэргүүн байр”
- “Гарбөмбөг” – ийн төрөлд “Дэд байр”
- “Сагсанбөмбөг”-ийн төрөлд “Дэд байр”



# Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

# 2023

"Миний дуртай үнэт цаасны эрх зүй клуб" байгуулагдлаа.



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллагуудын хуульч, эрх зүйч, комплаенс мэргэжилтнүүдийн гишүүнчлэлтэй "МИНИЙ ДУРТАЙ ҮНЭТ ЦААСНЫ ЭРХ ЗҮЙ КЛУБ"-г 2023 оны 04-р сарын 19-ны өдөр амжилттай үүсгэн байгуулсан. Тус клубийн Ерөнхий зохицуулагчаар СЭЗИС-ийн санхүү, банк, үнэт цаасны эрх зүйн гэрээт багш Б.Ган-Эрдэнэ, зохицуулагчаар "Кэй и Партнерс" ХХН-ийн партнер М.Лхамсүрэн, "Таван Богд Капитал ҮЦК" ХХК-ийн хуулийн зөвлөх Б.Учралбаяр, Easy цахим сургалтын үүсгэн байгуулагч Б.Цолмон нар ажиллахаар сонгогдсон юм.

Клуб нь 2023 онд нийт 3 удаагийн уулзалтыг амжилттай зохион байгуулаад байна. Үүнд:

1. 2023 оны 04-р сарын 18-ны өдөр "Компанийн эрх зүй" сэдвийн хүрээнд МУИС-ийн ХЗС-ийн ахлах багш, хууль зүйн доктор Г.Давааням;
2. 2023 оны 06-р сарын 14-ний өдөр "Үнэт цаасны зах зээлийн эрх зүй" сэдвийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга, хуульч, СЭЗИС-ийн дэд профессор Т.Жамбаажамц;
3. 2023 оны 08-р сарын 23-ны өдөр "Үнэт цаасны зах зээлийн өнөөгийн зохицуулалт, цаашдын чиг хандлага" сэдвийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн нар зочноор оролцлоо.

Цаашид клубийн үйл ажиллагааг өргөжүүлэх, Монголын хуульчдын холбоотой хамтран ажиллах, эрх зүйн чиглэлээр суралцаж буй оюутнуудын дунд ментор хөтөлбөр зарлахаар төлөвлөөд байна.



# Гишүүн байгууллага, 2023 мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

Үнэт цаасны компаниудын нягтлан бодогчдод зориулсан өглөөний уулзалт



Холбооны зорилтын хүрээнд Үнэт цаасны компаниудын нягтлан бодогчдын уялдаа холбоог сайжруулах, харилцан суралцах зорилгоор нягтлан бодогчдод зориулсан өглөөний уулзалтыг амжилттай зохион байгууллаа. Тус уулзалтад Холбооны гишүүн байгууллагуудын нягтлан бодогч нар оролцсон бөгөөд Урилгаар Татварын ерөнхий газар, Орлогын хяналт буцаан олголтын хэлтсийн дарга Д.Тунгалаг оролцож Үнэт цаасны зах зээлтэй холбоотой татварын тухай хуулийн заалтууд түүний хэрэглээ, Хөрөнгийн зах зээлийг дэмжсэн зохицуулалтууд, Татварын шинэчлэлт болон цаашдын чиг хандлагын талаар танилцууллаа.

Мөн Монгол улс дах виртуал хөрөнгийн зохицуулалт хууль эрх зүйн орчны талаар тэр дундаа Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Виртуал хөрөнгөнд хэрхэн татвар ногдуулах, Сэндбокс зохицуулалтын орчны журмын талаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

Уулзалтын үр дүнд гишүүн байгууллагуудын нягтлан бодох бүртгэл болон татварын хууль эрх зүйн хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг тус тусдаа шийдвэрлэх нь үр дүн бага учир гишүүн байгууллагуудад тулгарч буй асуудлуудыг МҮЦАЭХ-нд нэгтгэж холбооны зүгээс албан ёсоор хүргүүлэх нь үр дүнтэй гэж зөвлөлөө.



## Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

# 2023

Хонгконгийн хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн байгууллагуудаар зочиллоо.



Санхүүгийн зохицуулах хороо Хонгконгийн Санхүүгийн Үйлчилгээ, Төрийн Сангийн Хорооны (FTSB) нарийн бичгийн дарга Christopher Hui-тай Хонгконг, Макао дахь Монгол Улсын Ерөнхий консул болон бусад албаны төлөөллийн хамт албан уулзалт хийлээ. Уулзалтаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааны талаар танилцуулж, Хонгконгийн зах зээлээр дамжуулж Хонгконг болон олон улсаас хөрөнгө оруулалт татах, гадаадын хөрөнгө оруулагчдыг Монголын хөрөнгийн зах зээлд оролцох оролцоог нэмэгдүүлэх хүрээнд хоёр тал харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар ярилцсан юм.

Энэ уулзалтын үеэр Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Удирдах зөвлөл болон гишүүн байгууллагуудын төлөөллүүд ICMA, ASIFMA, Bank of China Hong Kong Asset Management, Zeal Asset Management, Hongkong Green Fund Association болон Хонгконгийн хөрөнгийн биржээр зочилж албан уулзалтууд хийлээ.

Тус уулзалтуудаар гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, олон улсын хөрөнгө оруулалтын ногоон сангуудыг Монгол Улсад хэрхэн анхаарал хандуулах талаар санал бодлоо солилцсон юм.



# Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

# 2023

**Холбоо нь татварын ерөнхий газартай уулзалт зохион байгууллаа.**



Тус уулзалтаар ХОС-ын үйл ажиллагааны хүрээнд олж буй орлогоос суутган төлөх албан татварыг суутгагч талд чөлөөлөгдсөн талаар мэдэгдэж суутгуулалгүйгээр авах суутгасан нөхцөлд дараа онд буцаан авах боломжтой талаар бидэнд тайлбар өгсөн юм.

Үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийдэг сангийн хувьд үл хөдлөх худалдан авах үедээ татвар төлөөд буцаан зарах үед үйл ажиллагааны орлого чөлөөлөгдсөн үндэслэлээр чөлөөлөгдөх тухай тус тус тайлбарлалаа.

Ийнхүү дээрх асуудлаар Татварын ерөнхий хуулийн 77.7.3-т зааснаар холбооноос нэгдсэн байдлаар албан хүсэлт явуулж зөвлөмж авахаар тохиролцсон бөгөөд заавар гарын авлага боловсруулж өгөх боломжтой тухай мэдэгдлээ. Мөн Холбооноос Татварын ерөнхий газарт хүсэлт гаргаж нэгдсэн сургалтыг зохион байгуулахаар тохиролцлоо.

Иймд Холбоогоор дамжуулан Сангийн яамны татварын бодлогын хэлтэс болон Татварын ерөнхий газарт санал, хүсэлтээ гаргах замаар хууль эрх зүйн орчны өөрчлөлтийн асуудлаар хамтран ажиллах боломжтой боллоо.



# Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

# 2023

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн зуучлагч брокерийн тусгай зөвшөөрөл авахаар төлөвлөж буй Холбооны гишүүн үнэт цаасны компаниуд Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржтэй уулзалт зохион байгууллаа.



УИХ-аас 2022 оны 12 сарын 23-ны өдөр Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсан бөгөөд 2023 оны 06 сарын 30-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх юм. Тус хуулийн Хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо нь оролцогчид тусгай зөвшөөрөл олгох, тохиромжтой этгээдийг тодорхойлох, мэдээллийн нэгдсэн сан бий болгох гэх мэт харилцааг зохицуулах зорилгоор холбогдох журмуудыг батлан захиргааны хэм хэмжээ тогтоосон актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яамд хүргүүлсэн.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг Монголын хөрөнгийн бирж гүйцэтгэхээр дотоод журмуудаа боловсруулж олон нийтээс санал авах ажиллагааг 2023 оны 06 сарын 05-нд эхлүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн зуучлагч брокерын тусгай зөвшөөрөл авахаар төлөвлөж буй Холбооны гишүүн Үнэт цаасны компаниуд Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржтэй уулзалт зохион байгууллаа.

МХБ ХК нь "Уул уурхайн бүтээгдэхүүний гишүүнчлэлийн журам", "Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны хяналт шалгалтын журам"-ыг оролцогчдод танилцуулсан юм. Эдгээр журмын төслүүдэд Холбооны удирдлага болон гишүүн оролцогчдын саналыг нэгтгэн СЗХ болон МХБ ХК-д хүргүүлээд байна. Мөн "Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөр тооцооны бэлэн байдлыг хангаж, тус хуульд заасан журмын төслүүдийг хамтран боловсруулах" чиг үүрэг бүхий ажлын хэсэгт Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Буянхишиг орж ажиллалаа.



# Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

# 2023



ҮЦТХТ нь дансны төлөв түр хаалттай харилцагчдийн мэдээллийг ҮЦК-уудад нь цахим хаягаар илгээлээ.

ҮЦТХТ болон Холбоо нь ойрын хугацаанд хийгдэж буй ажил, төлөвлөгөөг харилцан танилцуулж, зах зээлийн зарим зохицуулалт, харилцагч болон мэргэжлийн оролцогчдод үзүүлж буй үйлчилгээг хялбарчлах, сайжруулах талаар хамтын ажиллагаагаа идэвхжүүлэхээр тохиролцсон юм. Энэ уулзалтын үр дүнд тодорхой шат дараатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Үүнд:

Холбооны зүгээс Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид, дэд бүтцийн байгууллагуудын үйл ажиллагааны шат дамжлагыг хөнгөвчлөх, зардлыг бууруулах, мэдээллийн урсгалын давхардлыг арилгах, олон нийтэд зөв мэдээлэл хүргэх зэрэг зорилтын хүрээнд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн хаалттай төлөвтэй данснуудыг ҮЦК-уудад төлөв нээлгэх хүсэлт өгөхөөс өмнө ҮЦК-уудад мэдэх боломжоор хангах тухай саналыг хүргүүлсэн. ҮЦТХТ-д төлөв нээх боломжтой түр хаалттай төлөвтэй нийт 29 ҮЦК-иуд дээр нийт 112,352 данс байна.

Иймд Холбоо нь харилцагчийн түр хаалттай төлөвт байгаа дансны мэдээллийг ҮЦК-иуд API эсвэл бусад системийн холболтын аргуудаар хандалт хийж, шууд авах боломжтой систем бий болгох, харилцагчийн үйлчилгээ авч буй шат дамжлага, холбогдох зардлыг бууруулах боломжийг бүрдүүлэх санал дахин хүргүүлсэн. Энэ саналын хүрээнд эхний ээлжинд ҮЦТХТ нь дансны төлөв нь түр хаалттай иргэдийн мэдээллийг холбогдох ҮЦК-иудад албан ёсны цахим хаягаар нэг удаа хүргүүлэхээр боллоо.



# Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

# 2023

## Холбооны гишүүдийн “Зуны зугаалга-2023”



Холбооны гишүүн байгууллагууд болон хөрөнгийн зах зээлийн мэргэжилтнүүдийн харилцаа холбоог бэхжүүлэх, эрч хүчээр цэнэглэх зорилготой "Зуны зугаалга-2023" арга хэмжээг 06-р сарын 10-11 ний амралтын өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Гишүүн байгууллагын мэргэжилтнүүд маань хөрөнгийн зах зээлийн мэргэжилтнүүдтэйгээ танилцан, өдөр тутмын завгүй ажлаасаа завсарлага авч тархиа амраан цагийг хөгжилтэй өнгөрүүлж, морь унаж, байгалийн үзэсгэлэнт газруудаар аяллаа.

### Шилдэг морьтой авхуулсан зургийн ялагч:

Ц.Чанцал / Гүүдсек ҮЦК /

### Шилдэг мэргэн харваач баг:

Э.Билгүүн / Апекс капитал ҮЦК /

Б.Билэгжаргал /Ти ди би Секьюритис ҮЦК/

Ц.Гантөгс / Улаанбаатар үнэт цаасны бирж ХК/

М.Нямдэмбэрэл / Таван богд капитал ҮЦК /

П.Сэлэнгэ / Апекс капитал ҮЦК /

### Шилдэг ковер дуучин:

Д.Сүхбат / Апекс капитал ҮЦК /

СУРГАЛТ СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР



МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ  
АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО  
ӨӨРИЙГӨӨ ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГА




# Сургалт судалгааны чиглэлээр 2023

Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх олгох, аттестатчилах сургалтын тайлан




2023 онд эрх олгох сургалтыг 3-р сар, 10-р сард 2 удаа зохион байгуулсан бөгөөд үнэт цаасны зуучлалын чиглэлээр 69 хүн сургалтад хамрагдаж 53 иргэн, Хөрөнгө оруулалтын чиглэлээр 188 хүн сургалтад хамрагдаж, 155 иргэн шалгалтад тэнцэж 3 жилээр үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхээ авлаа.



Аттестатчиллаар 108 мэргэжилтэн сургалтад хамрагдаж 42 мэргэжилтэн 4 жилээр, 13 мэргэжилтэн 6 жилээр, 44 мэргэжилтний эрхийг хугацаагүйгээр тус тус сунгав. Холбоо нь "Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах сургалтыг 2011 оноос хойш 38 удаа зохион байгуулсан бөгөөд нийт 3866 хүнд хөрөнгө оруулалт, үнэт цаасны зуучлалын эрхийг шинээр олгосон бөгөөд эрх нь хүчинтэй байгаа 1549 мэргэжилтэн байна.





# Сургалт судалгааны чиглэлээр 2023

## Динамик сургалтын платформыг шинээр нэвтрүүлэв.



Холбоо нь 2023 оны 9-р сард "Gosmart" ХХК-тай гэрээ байгуулж динамик систем /e.masd.mn/-ийг нэвтрүүлж сургалтаа цахимаар зохион байгуулах боломжийг бүрдүүллээ. Динамик сургалтын платформ нь дараах давуу талуудтай байна. Үүнд:

- Сургалт
- Шалгалт
- Тестийн сан
- Сурагчдын мэдээллийн сан гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэж байгаа бөгөөд, системд оруулж буй хичээл, сургалт, шалгалтын материал, сургалтад хамрагдаж буй сурагчдын тухай гэх мэт бүх мэдээлэл хадгалагдах бөгөөд, дахин сургалт явуулахдаа тэдгээрийг ашиглах боломжтой байна. Сургалтын онцлогоос шалтгаалан төлбөрийг хичээлээр болон бүлэг хичээлээр тооцох боломжтой ба цахим төлбөрийн хэрэгслүүдийг ашиглан хэрэглэгч шууд төлөх, эсвэл тус байгууллагын мэдээллийг агуулсан цахим нэхэмжлэхийг системээс автоматаар үүсгэн илгээх гэсэн сонголттой цогц систем юм.



# Сургалт судалгааны чиглэлээр 2023

## Мэргэжилтнүүдийн “Тангараг өргөх ёслолын үйл ажиллагаа”



Монгол улсын үнэт цаасны зах зээлд мэргэшлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах сургалтын шалгалтад тэнцсэн мэргэжилтнүүдийн тангараг өргөх ёслолын арга хэмжээг 2 удаа зохион байгууллаа. Тангараг өргөх ёслолд Санхүүгийн зохицуулах хорооны гишүүн, Мэргэшлийн зөвлөлийн дарга Т.Цэрэнбадрал нээлтийн үг хэлж, Холбооны удирдах зөвлөлийн гишүүн, Үнэт цаасны боловсролын хорооны дарга М.Отгонбаатар, К.Алия нар мэргэжилтний тангараг уншиж, Холбооны Ёс зүйн хорооны дарга С.Өнөр, Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, сургагч багш Н.Улаанхүү нар шинээр эрхээ авсан мэргэжилтнүүдэд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах ёс зүйн дүрмийг танилцуулсан юм.

2023 оны хагас жилийн  
байдлаар компанийн  
засаглалын цахим сургалтад  
136 хүн хамрагдаж, гэрчилгээ  
авлаа.

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах сургалтыг 2011 оноос хойш 36 удаа зохион байгуулсан бөгөөд нийт 3702 хүнд хөрөнгө оруулалт, үнэт цаасны зуучлалын эрхийг шинээр олгосон бөгөөд эрх нь хүчинтэй байгаа 1385 мэргэжилтэн байна.

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЙЛАН





## Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээр

# 2023

Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журмыг Санхүүгийн зохицуулах хороо батламжиллаа.



МҮЦАЭХ-ны Удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 22/41 тоот тогтоолоор Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам батлагдаж, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 1-р дугаар сарын 11-ны өдрийн 17 дугаар тоот тогтоолоор батламжлагдан мөрдөж эхэлсэн.

Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор Андеррайтеруудын сургалт зохион байгуулагдсан. Уг сургалтаар шинэчлэн найруулсан бүртгэлийн журмын өөрчлөлтийг танилцуулж, цаашид Үнэт цаасны төслийн танилцуулга бэлтгэхэд анхаарах асуудал, андеррайтерийн гаргаж буй түгээмэл алдааны талаар хэлэлцлээ.



# Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээр

# 2023

## Биржийн бус зах зээлийн оролцогчидтой хамтарсан хэлэлцүүлэг



Биржийн бус зах зээлийн хяналт, зохицуулалт, өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зах зээлийн оролцогчидтой нээлттэй хэлэлцэх, талуудын оролцоог хангасан цаашдын хамтын ажиллагааг тодорхойлох зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо (МҮЦАЭХ), зах зээлд оролцогч андеррайтерийн компаниудын удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд оролцлоо.

Хэлэлцүүлгийг нээж Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал “Хорооны 2020 оны 995 дугаар тогтоолоор баталсан “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-аар МҮЦАЭХ нь биржийн бус зах зээлийг удирдан зохион байгуулах чиг үүрэг хүлээсэн. Тус зах зээлийн үйл ажиллагаа албан ёсоор эхэлсэн 2021 оны есдүгээр сараас хойших хугацаанд нийт 74 компанийн 1.53 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 94 өрийн хэрэгсэл гарсан бөгөөд 1.02 их наяд төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн. Харин энэ оны нэгдүгээр улиралд 16 үнэт цаас гаргагчийн 109.55 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий, 42 транч хэрэгслийг бүртгэж, 62.55 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлжээ. Өнөөдрийн байдлаар биржийн бус зах зээлийн шууд оролцогч болох үнэт цаасны 29 компани, шууд бус оролцогч 2126 этгээд байгаа бөгөөд нийт 2,155 оролцогч байна” гэдгийг онцлон дурдсан юм. Санхүүгийн зохицуулах хорооноос энэ үеэр биржийн бус зах зээлийн хяналт, зохицуулалт, өнөөгийн нөхцөл байдлын талаар танилцуулга, мэдээлэл өгсний зэрэгцээ оролцогчидтой санал солилцож, цаашид хийж хэрэгжүүлэх ажлаа тодорхойллоо.



# Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээр 2023

Удирдах зөвлөл ББЗЗ-н Бүртгэлийн хорооны гишүүдийн хамтарсан уулзалт



2023 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Удирдах зөвлөлийн гишүүд нь Бүртгэлийн хорооны гишүүдтэй уулзалт зохион байгуулсан юм. Тус уулзалтын хүрээнд дараах асуудлуудыг шийдвэрлэхээр боллоо.

## Үүнд:

1. Биржийн бус зах зээлийн үнэт цаасны Бүртгэлийн журмыг хэрэгжүүлэх гарын авлага, Үнэт цаасны төслийн танилцуулга бэлтгэх зааврыг үлгэрчлэн загварчлах; /Энэ ажлын хүрээнд Бүртгэлийн хорооны гишүүдтэй хамтран гарын авлага, үлгэрчилсэн загварыг боловсруулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна/

2. Андеррайтеруудыг чадавхжуулах сургалт зохион байгуулах; /Энэ ажлын хүрээнд Гишүүн байгууллагуудын захирал, удирдах албан тушаалтнуудаар видео хэлбэрээр сургалтын гарын авлага, контент хийлгүүлэх, мөн мэргэжлийн багш нартай хамтран 2023 оны III улиралд багтаан академик сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна/

3. ББЗЗ-д андеррайтерийн үйл ажиллагаа явуулж буй компаниудын төлөөлтэй зах зээлийн өнөөгийн байдал, цаашид хийгдэх болон хийгдэж буй ажлуудыг талаар уулзалт зохион байгуулсан бөгөөд 2023 оны 05 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд андеррайтеруудын төлөөлөлтэй Биржийн бус зах зээлийн мэргэжилтнүүд хамтарсан уулзалтыг зохион байгуулсан юм. Тус уулзалтын хүрээнд "Голомт капитал ҮЦК" ХХК, "Апекс капитал ҮЦК" ХХК, "Мандал капитал маркетс ҮЦК" ХХК, "Би Ди Сек ҮЦК" ХХК, "Таван богд капитал ҮЦК" ХХК, "Өлзий энд ко ҮЦК" ХХК, "Стандарт инвестмент ҮЦК" ХХК-иудтай Мэргэжлийн хөрөнгө оруулагчийн шаардлага, Үүргийн гүйцэтгэл хангах арга, OTC.MN Platform, Бүртгэлийн хорооны гишүүд, Бүртгэлийн журамд оруулах өөрчлөлт зэрэг асуудлуудыг хэлэлцэж, андеррайтеруудаас ирүүлсэн шийдвэрлэх боломжтой санал хүсэлтийг 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн Удирдах зөвлөлийн ээлжит хурлаар танилцуулан, шийдвэрлэн ажиллаж байна.



# Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээр 2023

**ББ33-ийн блокчэйн арилжааны системийг Сэндбокс зохицуулалтын орчинд туршихаар боллоо.**



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь "Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам"-ын дагуу Монголын Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж 2021 оны 9-р сарын 7-ны өдөр М-ОТС арилжааны платформын үйл ажиллагаа эхэлсэн цагаас хойш платформын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байгаа. Биржийн бус зах зээлийн арилжааны платформын хөгжүүлэлтийг Холбооны удирдлага дор "Анд Системс" ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан бөгөөд Холбоо нь М-ОТС арилжааны платформыг хөгжлийн дараагийн үе шатанд гаргаж, сэндбоксын зохицуулалттай орчинд блокчэйн технологи ашигласан нь дэлхийд анх удаа зохицуулалттай орчинд блокчэйн үнэт цаас арилжаалах арилжааны платформыг хөгжүүлж ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны Сэндбоксын зөвлөлийн тавдугаар хуралдаанаар ББ33-ийн блокчэйн арилжааны системийг хэлэлцэж сэндбокс зохицуулалтын орчинд нэг жилийн хугацаатай туршихаар боллоо.

Иймд Биржийн бус зах зээлийн арилжаанд блокчэйн системийг нэвтрүүлснээр үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа, төлбөр тооцоог автоматаар, цагийн хязгаарлалтгүй 24/7 гүйцэтгэх боломж бүрдэх юм.

Одоогийн байдлаар Биржийн бус зах зээлийн блокчэйн арилжааны системд хөгжүүлж буй платформд анх удаа арилжаагаа явуулахаар 2 үнэт цаас гаргагч хүсэлтээ өгөөд байна.

# Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээр

# 2023

## Арилжааны тайлан




Биржийн бус зах зээлд 2023 оны байдлаар нийт 63 үнэт цаас гаргагчийн, 195 транч өрийн хэрэгсэл бүртгэгдлээ. Үүнээс төгрөгөөр 1,065,705,500,000 үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдэж, 836,542,500,000 төгрөгийг татан төвлөрүүлэхээр зарласнаас 829,455,500,000 төгрөгийг бодит татан төвлөрүүлсэн байна. Харин доллароор 59 сая ам.долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдэж, 33.5 сая ам.доллар татан төвлөрүүлэхээр зарласнаас 33.5 сая ам.долларыг амжилттай татан төвлөрүүлсэн байна.

Ингэснээр биржийн бус зах зээл 2021 оны 9 сард анхны өрийн хэрэгслээ бүртгэж үйл ажиллагаагаа эхэлснээс хойш төгрөгөөр 2,441,400,145,526 үнийн дүн бүхий өрийн хэрэгслийг бүртгэж, 1,781,855,435,526 төгрөгийг татан төвлөрүүлэхээр зарласнаас 1,743,095,776,326 төгрөгийг бодит татан төвлөрүүлсэн байна. Харин доллароор 71 сая ам.долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдэж, 45.5 сая ам.доллар татан төвлөрүүлэхээр зарласнаас 45.5 сая ам.долларыг амжилттай татан төвлөрүүлсэн байна.

■ Нийт: 2021/9-2023/12 ■ Нийт: 2023 он

Бүртгүүлсэн бондын график




Нийт бүртгэгдсэн дүн

Нийт зарласан дүн

Бодит татан төвлөрүүлсэн дүн

### Салбараар ангилбал:

Тайлант хугацаанд бүртгэгдсэн өрийн хэрэгслийг салбараар нь ангилбал, Банк бус санхүүгийн байгууллага 41%, Санхүү 9%, Уул уурхай 4%, Гадаад худалдаа, борлуулалт 11%, Үл хөдлөх 18%, Худалдаа, үйлдвэрлэл 10%, Бусад 7% тус тус бүрдүүлж байна.




# Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээр

# 2023


## Арилжааны тайлан



Тайлант хугацаанд бүртгэгдсэн өрийн хэрэгслийн төгрөгийн дундаж хүү 17,86%, доллароор бүртгэгдсэн өрийн хэрэгслийн дундаж хүү 9,54% байгаа бөгөөд 12, 18, 24, 36, 48 сарын хугацаатайгаар тус тус бүртгэгдсэн байна.



Бондын хүүгийн төлөлт хийгдэх давтамж нийт бүртгэгдсэн бондын 65% нь улирал тутам, 21% хагас жил тутам, 12% нь сар бүр, 3% нь хугацааны эцэст төлөлт хийгдэхээр төлөвлөгдсөн.



Биржийн бус зах зээл 2021 оны 9 сард анхны өрийн хэрэгслээ бүртгэж үйл ажиллагаагаа эхэлснээс хойш нийт 389,035,340,400 төгрөгийн өрийн хэрэгслийн хугацаа дуусаж, амжилттай эргэн төлөлт хийгдсэн ба 2023 онд 303,006,340,400 төгрөгийн эргэн төлөлтийг амжилттай хийж гүйцэтгэсэн байна.

## Эргэн төлөлтийн график



# Биржийн бус зах зээл 2023

Биржийн бус зах зээл дээр үнэт цаас гаргагч компаниуд.

- Бүртгүүлсэн дүн
- Татан төвлөрүүлсэн дүн



"АБТС ББСБ" ХХК  2,000,000,000₮ 2,000,000,000₮	"Таван богд финанс ББСБ" ХХК  61,500,000,000₮ 45,000,000,000₮	"Нью ярмаг хаусинг проект" ХХК  6,000,000,000₮ 3,000,000,000₮	"Голомт Капитал ҮЦК" ХХК  4,000,000,000₮ 4,000,000,000₮	"Мандал дижитал кредит ББСБ" ХХК  1,750,000,000₮ 1,750,000,000₮	"Солонго капитал ББСБ" ХХК  700,000,000₮ 700,000,000₮	"Үйзэн-Ивээлт ББСБ" ХХК  1,400,000,000₮ 1,400,000,000₮	"Актив Гарден" ХХК  31,600,000,000₮ 9,300,000,000₮	"Ноткапитал Авто" ХХК  34,400,000,000₮ 14,400,000,000₮
"Эхлэл брэнд" ХХК  2,000,000,000₮ 2,000,000,000₮	"Монгол телевиз" ХХК  10,000,000,000₮ 5,000,000,000₮	"Булл Капитал ББСБ" ХХК  5,600,000,000₮ 5,600,000,000₮	"Шунхлай" ХХК  50,000,000,000₮ 50,000,000,000₮	"Боса импекс" ХХК  5,000,000,000₮ 5,000,000,000₮	"Микро Кредит ББСБ" ХХК  2,000,000,000₮ 2,000,000,000₮	"Мөнхийн усга" ХХК  3,000,000,000₮ 3,000,000,000₮	"Цэцэнс майнинг энд энержи" ХХК  141,491,000,000₮ 2,000,000,000₮	"Жи эс би капитал ББСБ" ХХК  20,000,000,000₮ 20,000,000,000₮
"Бичил Глобус Финанс ББСБ" ХХК  9,341,000,000₮ 9,341,000,000₮	"Минж Проперти" ХХК  6,000,000,000₮ 6,000,000,000₮	"Соно Финтек ББСБ" ХХК  14,000,000,000₮ 14,000,000,000₮	"Говь финанс ББСБ" ХХК  600,000,000₮ 600,000,000₮	"Омини Капитал ББСБ" ХХК  5,000,000,000₮ 5,000,000,000₮	"Адоресити" ХХК  8,000,000,000₮ 4,606,000,000₮	"Урбан бизнес групп" ХХК  1,500,000,000₮ 1,500,000,000₮	"Смарт Дийл" ХХК  1,000,000,000₮ 1,000,000,000₮	"Мөнхийн тун" ХХК  4,000,000,000₮ 4,000,000,000₮
Монгол Улсын хөгжлийн Банк  346,008,500,000₮ 346,008,500,000₮	"НВЦ Трейдинг" ХХК  4,200,000,000₮ 4,200,000,000₮	"Нөмөр Кредит ББСБ" ХХК  13,800,000,000₮ 13,800,000,000₮	"Ашид голомт ББСБ" ХХК  2,000,000,000₮ 2,000,000,000₮	"Зээл Эм Эн платформ ББСБ" ХХК  1,500,000,000₮ 750,000,000₮	"Монголын финтек групп" ХХК  10,000,000,000₮ 7,000,000,000₮	"Кредитех СТМ ББСБ" ХХК  1,250,000,000₮ 1,250,000,000₮	"Грин индустри" ХХК  10,000,000,000₮ 9,000,000,000₮	"Тера анимитед" ХХК  5,000,000,000₮ 3,000,000,000₮
"Монкон констракшн" ХХК  10,000,000,000₮ 10,000,000,000₮	"Атмор" ХХК  1,000,000,000₮ 1,000,000,000₮	"Баясах Хульж" ХХК  2,000,000,000₮ 2,000,000,000₮	"Блүүм технологи" ХХК  3,000,000,000₮ 0₮	"Хүннү Эйр" ХХК  20,000,000,000₮ 20,000,000,000₮	"Жем трейд" ХХК  28,000,000,000₮ 28,000,000,000₮	"Альфа зон" ХХК  20,000,000,000₮ 15,100,000,000₮	"Агро Ворлд" ХХК  2,500,000,000₮ 2,500,000,000₮	"Мастер түншлэл" ХХК  6,500,000,000₮ 6,500,000,000₮
"Бэрс финанс ББСБ" ХХК  8,000,000,000₮ 8,000,000,000₮	"Грин интернэшил" ХХК  10,000,000,000₮ 10,000,000,000₮	"Премиум Конкрит" ХХК  5,000,000,000₮ 5,000,000,000₮	"Монибокс" ХХК  10,000,000,000₮ 8,000,000,000₮	"Мишээл Лайф Стайл" ХХК  2,000,000,000₮ 2,000,000,000₮	"Бизнес инвестмент девелопмент ББСБ" ХХК  5,000,000,000₮ 5,000,000,000₮	"Эдванс кредит ББСБ" ХХК  965,000,000₮ 965,000,000₮	"Траст Финанс ББСБ" ХХК  1,500,000,000₮ 1,500,000,000₮	"Бүрэн Финанс ББСБ" ХХК  2,800,000,000₮ 1,500,000,000₮
"Инвекор ББСБ" ХХК  50,000,000,000₮ 36,300,000,000₮	"Токи ББСБ" ХХК  150,000,000₮ 150,000,000₮	"Баяншууу" ХХК  5,000,000,000₮ 500,000,000₮	"Төв Азийн зам" ХХК  2,000,000,000₮ 2,000,000,000₮	"ЛэндМН" ББСБ ХХК  5,000,000,000₮ 0₮	"Гэрэл финанс ББСБ" ХХК  2,000,000,000₮ 2,000,000,000₮	"Нэкс Дистрибьюшн" ХХК  10,000,000,000₮ 2,000,000,000₮	"Бумбын шовх" ХХК  20,000,000,000₮ 0₮	"Домог импекс" ХХК  10,000,000,000₮ 0₮

# Биржийн бус зах зээл

# 2023



## Биржийн бус зах зээлийн шууд оролцогч

№	Шууд оролцогчид	Андеррайтер	Дилер	Брокер	ХОС
1	Өлзий энд ко капитал ҮЦК	✓	✓	✓	
2	Инвескор капитал ҮЦК	✓	✓	✓	
3	Стандарт инвестмент ҮЦК	✓	✓	✓	
4	Эм ай си си ҮЦК	✓	✓	✓	
5	Ард секюритиз ҮЦК	✓	✓	✓	
6	Гүүдсек ҮЦК	✓	✓	✓	
7	Голомт капитал ҮЦК	✓	✓	✓	
8	Мирэ эссет секьюритис Монгол ҮЦК	✓	✓	✓	
9	Би Ди СЕК ҮЦК	✓	✓	✓	
10	Гаули ҮЦК	✓	✓	✓	
11	Нэйшнл секюритис ҮЦК	✓	✓	✓	
12	Алекс капитал ҮЦК	✓	✓	✓	
13	Тэнгэр капитал ҮЦК	✓	✓	✓	
14	Бумбат Алтай ҮЦК			✓	
15	Зэргэд ҮЦК		✓	✓	
16	Райнос инвестмент ҮЦК		✓	✓	
17	Ти Ди Би Капитал ҮЦК	✓	✓	✓	
18	Аргай бест ҮЦК		✓	✓	
19	Таван богд капитал ҮЦК	✓	✓	✓	
20	Гацуурт трейд ҮЦК		✓	✓	
21	Мандал капитал маркетс ҮЦК	✓	✓	✓	
22	Тээвэр хөгжлийн банк ХХК	✓			
23	Монсек ҮЦК		✓	✓	
24	Стоклаб секюритиз ҮЦК			✓	
25	Новел инвестмент ҮЦК	✓	✓	✓	
26	Сод аллокэйшн хувийн ХОС ХХК				✓
27	Ашид арвижих хамтын ХОС ХХК				✓
28	Алтан хоромсог ҮЦК ХХК		✓	✓	
29	Нийслэлийн эрсдэлийн удирдлагын сан хувийн ХОС ХХК				✓
30	Ди эйч капитал ҮЦК ХХК		✓	✓	
31	Мазаалай капитал партнерс ҮЦК ХХК			✓	

# 2023 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо  
Өөрийгөө зохицуулах байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайлан